



ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМ



УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР



НИИСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР

 IOM  
UN MIGRATION



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарийн хөгжлийн агентлаг

# ШИЛЖИН СУУРЬШИХ 10 ЗӨВ АЛХАМ

Гарын авлага



МЭДЬЕ, СУДАЛЪЯ  
ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНД  
ХАРИУЦЛАГАТАЙ ОРОЛЦЪЁ



Та шилжин суурьшихаар төлөвлөж байвал энэхүү

**Шилжин суурьших 10 зөв алхмыг мөрддөрэй.**

Шилжилт хөдөлгөөнөө сайтар төлөвлөж, судалж, хариуцлагатай хандах нь таныг болон танай гэр бүлийг олон эрсдэлээс хамгаалж, эрхээ эдлэх, аливаа боломжоос хүртэх, цаг хэмнэхэд туслах болно.

## Алхам 1.

**ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН БОЛ  
ГЭР БҮЛИЙН ХАМТЫН ШИЙДВЭР:**

Шилжин суурьшихдаа гэр бүлийн гишүүн нэг бүрийн санал бодлыг сайтар сонсож, ярилцаж, шилжин суурьших шийдвэрийг хамтдаа гаргаарай. Учир нь шилжилт хөдөлгөөн бол таны гэр бүлийн гишүүн бүрийн амьдралын чухал, хариуцлагатай алхам юм шүү.

## Алхам 2.

**ШИЛЖИН СУУРЬШИХ ГАЗРАА  
ТҮРҮҮЛЖ ОЧИЖ, СУДЛАХ:**

Та шилжихээр төлөвлөж буй газартаа өөрийн биеэр очиж, судлахыг зөвлөө. Ингэснээр ойролцоох сургууль, цэцэрлэгийн хүртээмж, эмнэлэг, худаг, автобусны буудал, хорооны байршил зэргийг мэдэж авахаас гадна хорооны нийгмийн ажилтнаас хэрэгцээт мэдээлэл авах зэрэг олон давуу талтай.

### Алхам 3.

**ШИЛЖИН СУУРЬШИХ ЦАГ  
ХУГАЦААГ ТӨЛӨВЛӨХ:**

Шилжин суурьших газраа дасан зохицох, төвхнөх 3 сарын хугацааг өөртөө болон гэр бүлдээ төлөвлөөрэй.

Ялангуяа та оршин суух газар, ажлын байр, сургууль, цэцэрлэг зэргийг хайх бол энэ хугацааг заавал төлөвлөгөөндөө тусгах шаардлагатай.

Мөн уг хугацаанд зарцуулагдах өрхийн зардлыг тооцоолж, хадгалахыг зөвлөө.

### Алхам 4.

**САНХҮҮГИЙН БАЙДЛАА  
ТООЦООЛЖ, ХУРИМТЛУУЛАХ:**

Шилжин суурьшихаар очиж буй газрынхаа амьдралын өртөг одоогийн амьдарч буй газрынхаас хэр зөрүүтэйг тооцоолон, өрхийн сарын хэрэглээг бодитоор тооцож, хуримтлуулаарай. Зардлаас гадна зохих хуримтлалтай байх нь амьдралд гарч болох олон гэнэтийн эрсдэл, хэрэгцээт үед хэрэг болно.





## Алхам 5.

### ШААРДЛАГАТАЙ БИЧИГ БАРИМТУУДАА БЭЛДЭХ:

Танд болон танай гэр бүлд шилжин суурьшихад шаардлагатай бичиг баримтуудыг сайтар судалж бэлдэж эхлээрэй. Чухал бичиг баримтуудаа эртнээс бэлтгэх нь цаг хэмнэхээс гадна албан ёсны бүртгэл хийлгэх, сургууль цэцэрлэгт хамрагдах, ажилд ороход чухал хэрэгцээтэй.

### Шаардлагатай бичиг баримтууд:

- Иргэний үнэмлэх;
- 16 нас хүрээгүй хүүхдийн төрсний гэрчилгээ;
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчийн хувийн хэрэг;
- Гэр бүлийн гишүүдийн амбулаторийн үзлэгийн карт болон эрүүл мэндтэй холбоотой бусад бичиг баримтууд;
- Жолооны үнэмлэх;
- Боловсролын гэрчилгээ, диплом, сертификатууд;

*Одоогийн авч буй тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг шилжин очсон газартаа үргэлжлүүлэн авах боломжтой эсэхийг нийгмийн халамжийн ажилтнаас лавлан, шаардагдах бичиг баримтуудыг бэлдээрэй.*

## Алхам 6.

### ОРШИН СУУХ ХАЯГ, АМЬДРАХ ГАЗРАА БЭЛДЭХ:

Шилжин суурьшихаасаа өмнө шийдсэн байх ёстой хамгийн чухал зүйл бол оршин суух хаяг, амьдрах орон байр юм. Оршин суух хаяг тодорхой байх нь танай гэр бүлийн гишүүдийг албан ёсны оршин суугчаар бүртгүүлж, нийгмийн суурь үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг нээж өгдөг.

### С Э Р Э М Ж Л Ү Ү Л Э Г

Орон сууц, хашаа, байшин худалдан авах гэж байгаа бол худалдан авахын өмнө улсын бүртгэлийн байгууллагаас уг байр, хашаа, байшин тухайн хүний өмчлөлийн хөрөнгө мөн болох, барьцаанд тавигдаагүй эсэх талаар лавлагаа авах, худалдах, худалдан авах гэрээг нотариат дээр байгуулах ёстой. Эд хөрөнгийн бичиг баримтаа өгөхийн өмнө банканд дундын данс нээлгэж, худалдан авсан төлбөрийг байршуулан, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөлийн гэрчилгээ гарсны дараа дундын данснаас төлбөрийг худалдагч талд шилжүүлээрэй.



## Алхам 7.

### АЛБАН ЁСНЫ БҮРТГЭЛ ХИЙЛГЭХ:

Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хийгдэх хамгийн чухал алхам бол шилжин суурьшсан нутаг дэвсгэртээ оршин суугчаар **бүртгүүлэх** юм. Ингэснээр та болон таны гэр бүл хуулиар олгогдсон олон эрхээ эдлэх, нийгмийн суурь үйлчилгээ авах боломж нээгдэнэ.

#### Хэзээ, хаана бүртгүүлэх вэ:

Шилжин суурьшсанаас хойш 10 хоногийн дотор харьяаллын хороон дээр өөрийн биеэр очин, хорооны улсын бүртгэгчид бүртгүүлнэ. Та өөрийн харьяаллын хорооны байршил болон бусад мэдээллийг хөршүүдээсээ асууж, мэдэж аваарай.

#### Шаардагдах бичиг баримтууд:

- Иргэний үнэмлэх;
- 16 нас хүрээгүй хүүхдийн төрсний гэрчилгээ;
- Оршин суух газрын хаягаа нотлох баримт бичиг;
- Хэрэв цэргийн бүртгэлд хамрагдах бол тэмдэглэлээ хийлгэсэн цэргийн үүрэгтний үнэмлэхээ шилжин очсон газраа авч очно.

#### Бүртгүүлсний дараа:

##### **БОЛОВСРОЛ:**

- Шилжин суурьших сум, хорооны нийгмийн ажилтнаас харьяаллын сургууль, цэцэрлэгийн нэр, байршлыг тодруулах;
- Тухайн боловсролын байгууллагын

нийгмийн ажилтан болон сургалтын менежертэй уулзан элсэлтийн журам, анги дүүргэлтийн талаар урьдчилан судалж, шаардлагатай материалыг бүрдүүлэх.

##### **ЭРҮҮЛ МЭНД**

- Танай гэр бүлд анхан шатны эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх газар бол өрхийн эмнэлэг учраас харьяа өрхийн эмнэлэг болон эрүүл мэндийн төвийн байршлыг тогтоон, мэдэж авах;
- Өрхийн эмнэлгээс ямар эрүүл мэндийн үйлчилгээ авч болох талаар судлах. Улсын томоохон эмнэлгүүдэд үзүүлэхэд өрхийн эмчийн тодорхойлолт шаардагдах нь бий.

##### **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ХӨНГӨЛӨЛТ, ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ**

- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авах бол шаардлагатай бичиг баримтуудыг нягтлах, бэлтгэх;
- Харьяа хорооны нийгмийн ажилтанд хандан, өмнө нь авч байсан нийгмийн халамжийн үйлчилгээг үргэлжлүүлэн авах хүсэлт гаргах.



## Алхам 8.

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ: АЖЛЫН БАЙР ОЛСОН БОЛ

Баталгаатай ажлын байр, тогтмол орлого нь шилжин суурьшсан газартаа таны тогтвортой оршин суух нөхцөлийг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй.

Хэрэв та шилжин суурьших газартаа ажлын байр олсон бол:

- Ажил олгогчоос ажилд ороход бүрдүүлэх шаардлагатай бичиг баримтын талаар лавлаж, бэлтгэх;
- Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээний нөхцөлийн талаар ярилцаж, хөдөлмөрийн гэрээг заавал бичгээр байгуулах;

## Алхам 9.

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ: АЖЛЫН БАЙР ОЛООГҮЙ БОЛ

Тогтвор суурьшилтай ажил, орлоготой болоход багагүй хугацаа хэрэгтэй. Ялангуяа нийслэл Улаанбаатар хотод ажиллаж, хөдөлмөрлөхөд насны хязгаар, албан ёсны оршин суух бүртгэл, мэргэжил, ур чадвар гээд танаас олон зүйл шаардагдана.

#### Ажлын байр хайх боломжууд:

- Шилжин суурьшиж буй нутаг дэвсгэрийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтсээс хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн чиг баримжаа, ур чадвар олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулдаг эсэх, ажлын байранд зуучлах үйлчилгээнд хамрагдах;

- Харьяаллын хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст хандах эсвэл цахим мэдээллийн санд бүртгүүлэх;
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын цахим хуудсанд (<http://hudulmur-halamj.gov.mn/job/list>) ажил хайгчаар бүртгүүлэх, ажлын заруудтай танилцах.

## С Э Р Э М Ж Л Ү Ү Л Э Г

Та хөдөлмөрийн мөлжлөгөөс болгоомжилж, хөдөлмөрийн гэрээ байгуулалгүй аман гэрээ байгуулан ажил хөдөлмөр эрхлэхээс зайлсхийх. Туршилтын хугацаагаар 3 сараас дээш хугацаагаар ажиллуулах нь Монгол улсын хөдөлмөрийн хуулийг зөрчсөн үйлдэл юм. Та ажил олгогчоосоо НД болон ЭМД төлөхийг шаардах эрхтэй.

## Алхам 10.

### ИХ ХОТЫН СОЁЛД СУРАЛЦАХ

Та нийслэл Улаанбаатар хот руу шилжин суурьшихаар төлөвлөж байгаа бол хотод амьдрах зөв дадал хэвшил, зөв хандлагыг өөртөө болон гэр бүлдээ бий болгож, ил задгай нус цэр, хог, угаадас зэргийг хаяхгүй, асгахгүй байх шаардлагатай.

Мөн нийслэл хотод нэвтэрсэн техник технологийн дэвшил болох нийтийн тээврээр зорчих, сайжруулсан түлш авах, худгаас ус авах ухаалаг картуудыг хэрэглэж сураарай.



# НҮҮХ ҮҮ СУУХ ҮҮ СУДАЛҮЯ

Мэдээллийн аяны хүрээнд бэлтгэв

## ☎ ТАНД ХЭРЭГТЭЙ УТАСНЫ ЖАГСААЛТ:

Гал түймэртэй тэмцэх алба:	101
Цагдаагийн газар:	102
Нийслэлийн яаралтай тусламжийн төв:	103, 7012 0103
Гамшиг ослын дуудлага:	105
Гэр бүлийн хүчирхийллийн газар:	107
Хүүхдийн түргэн тусламж:	108
Хүний эрхийн Үндэсний Комисс:	7000 0222
Нийслэлийн онцгой байдлын ерөнхий газар:	325726, 265726
Нийслэлийн шуурхай штаб:	324207
Улсын бүртгэлийн ерөнхий газар:	1800-1890
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар:	7771 220
Нийслэлийн Нийгмийн халамжийн газар:	7611 2112, 7707 3077
Монголын хуульчдын холбоо:	7011 6004, 7011 6065
Монголын өмгөөлөгчдийн холбоо:	7012 7491, 7012 6861
Хууль зүйн үндэсний хүрээлэн:	1800-1202

☎ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ БҮРТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЛИЙГ

ИРГЭД, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ТӨВИЙН **11-11** ЗАЛГААД **4** ДУГААРЫГ СОНГООД ОПЕРАТОРТАЙ ХОЛБОГДОЖ МЭДЭЭЛЭЛ АВААРАЙ